

“ДАРЬ ФИНАНС ББСБ” ХХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

Хувилбар № 1

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	2
ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ	2
ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС САНАЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН, АВАХ, ШИЙДВЭРЛЭХ	3
ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА	3

"Дарь Финанс ББСБ" ХХК

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн зорилго нь “Дарь Финанс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчдод компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц үйл явдал, засаглал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэлийн талаар мэдээлэл хүргэх, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрэхийг зорино.
 - 1.2.1. Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь хангах;
 - 1.2.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;
 - 1.2.3. Компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох буюу компанийн хувьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчдыг хангах;
 - 1.2.4. Компанийн засаглалын олон улсын зарчимд нийцсэн хөрөнгө оруулагчтай харилцах мэдээллийн сувгийг бий болгосноор ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэнэ болон компанийн засаглалыг сайжруулах.
- 1.3. Энэхүү хөтөлбөрийг Монгол Улсын хууль тогтоомж, компанийн дүрэм, журам, зааварт нийцүүлэн боловсруулав.

ХОЁР. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 2.1. Компани нь хөрөнгө оруулагчдад дор дурдсан мэдээллийг компанийн цахим хуудас эсвэл албан мэйлээр дамжуулан тухайн хөрөнгө оруулагчид саадгүй хүргэнэ.
 - 2.1.1. Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
 - 2.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;
 - 2.1.3. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой тухай бүр хүргэх мэдээлэл;
 - 2.1.4. Зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;
 - 2.1.5. Хөрөнгө оруулагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал;
 - 2.1.5. Компанийн шаардлагатай бусад мэдээлэл.
- 2.2. Хөтөлбөрийн 2.1-д заасан мэдээллийг хүргэхдээ Компанийн Тогтвортой хөгжлийн бодлогод тусгасан хүний эрхийн мэдрэмжтэй, тэгш хүртээмжтэй зарчмыг баримтална.
- 2.3. Компани нь дор дурдсан хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана.
 - 2.3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;
 - 2.3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас бусад үед хөрөнгө оруулагчаас гаргасан санал хүсэлтийг цахимаар, амаар болон биечлэн хүлээн авч хариуг хүргүүлнэ.

2.3.3 Хөрөнгө оруулагчид хариу хүргэхдээ Компанийн Мэдээллийн аюулгүй байдлын ерөнхий журмыг баримтлах бөгөөд энэ хөтөлбөрийн 3-р бүлэгт заасны дагуу хүргэнэ.

2.3.4 Шаардлагатай тохиолдолд бусад хэлбэрээр хүргэнэ.

ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС САНАЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН, АВАХ, ШИЙДВЭРЛЭХ

- 3.1. Хөрөнгө оруулагч нь өөрийн санал, хүсэлтээ Гүйцэтгэх удирдлагад өөрийн биеэр эсвэл албан мэйлээр, цаасаар, цахимаар өгч болно.
- 3.2. Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэхдээ мэдээллийн нууцлалыг хангаж, хүний эрхийг хүндэтгэх зарчмыг баримтална.
- 3.3. Хөрөнгө оруулагчийн ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авсан тэр даруй Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /цаашид “ТУЗНБД” гэх/-д хүлээлгэн өгнө.
- 3.4. ТУЗНБД нь санал, хүсэлт, гомдолтой танилцаж, бүртгэн ТУЗ-ийн зохих хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- 3.5. ТУЗ-ийн хороо нь санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэхдээ хөрөнгө оруулагчийн хуульд заасан эрхийг хүндэтгэж, мэргэжлийн ёс зүйтэй байж холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэм журмыг баримтлан цаг хугацаанд нь хурдан шуурхай шийдвэрлэж, хэрэгжилтийг хангахыг ТУЗНБД-д даалгана.
- 3.6. ТУЗНБД нь шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар Гүйцэтгэх удирдлагад чиглэлийг өгч, тус чиг үүргийн хэрэгжилтийг Гүйцэтгэх удирдлагаас ТУЗНБД-д тайлагнана.
- 3.7. Хөрөнгө оруулагчийн гаргасан санал хүсэлт, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор хариуг цаасаар, цахимаар хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд Компанийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр тус хугацааг ажлын 5 хүртэлх хоногоор сунгаж болно.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

- 4.1. ТУЗНБД нь хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх тайлан мэдээллийг компанийн ТУЗ-ийн хуралд тайлагнана.

--oOo--